



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 5/04

Улаанбаатар хот

Г.Дашнямыг ажлаас халах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 40.1.4, 43.1, 131.1.3, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.5, Захиргааны ерөнхий хуулийн 26.1, 27.3, 92.1, 94.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын Эрдэм шинжилгээний ахлах зөвлөх Гонгорын Дашням нь Архивын ерөнхий газрын дотоод журмын 4.2.9, 4.2.10, 10.7 дахь заалтууд болон Архивын ерөнхий газартай байгуулсан Б17/41-х-16 дугаартай хөдөлмөрийн гэрээний 13.1.9 дэх заалтыг удаа дараа ноцтой зөрчсөн тул 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрөөр тасалбар болгон ажлаас нь халсугай.

2. Г.Дашнямын ажлыг зохих журмын дагуу хүлээн авахыг Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын дарга Б.Цэндсүрэнд даалгасугай.

3. Г.Дашнямтай ээлжийн амралтын болон бусад санхүү, аж ахуйн тооцоог хийж дуусгахыг Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Б.Цэвэлмаад, тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч Ч.Оюунчимэгт үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ХОРОЛДАМБА



Tushaal

368110032